



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ШИНЭЖИНСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ



2024 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А/104

Залаа

Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй  
зээл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалаар батлагдсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 6 дугаар зүйлийн 6.7, 6.8 дахь заалт, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 91 дүгээр тогтоолоор байгуулагдсан "Төсөл сонгон шалгаруулах хороо"-ны 2023 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хоршоог хөгжүүлэх сангаас "Цармын цагаан сувд" (РД: 3132579) хоршоонд урд онд дутуу олгогдсон 30000000 (Гучин сая) төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг нөхөн олгосугай.

2.Гэрээний дагуу төслийн санхүүжилтийг "Цармын цагаан сувд" хоршооны Төрийн банкин дахь 231800119790 тоот дансанд шилжүүлэхийг Тусгай сан, соёл хариуцсан нягтлан бодогч (С.Хишигтогтох)-д зөвшөөрсүгэй.

3.Зээлийн эргэн төлөлтийг хуваарийн дагуу төлж, зээлийг зориулалтын дагуу ашиглахыг "Цармын цагаан сувд" хоршоо (Дарга З.Амартүвшин)-нд үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт тавих орон тооны бус зөвлөлийн дарга (Х.Энхтөр)-д даалгасугай.

ДАРГА  Б.БАТ-ЭРДЭНЭ

642301142